ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2026/128/НА-СТА-ТШЗ**

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитор Л.Баянмөнх
Утас: 99997540
Цахим хаяг: bayanmunkhamina@gmail.com

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....2**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....4**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....4**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....5**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....6**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....8**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....8**

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....9**

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....16**

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.25 № 57

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Б.МӨНХЧИМЭГ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дундговь аймгийн Өлзийт сумын Эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 7 нэр төрлийн үндсэн хөрөнгийг тусгай зориулалтын бараа материалын дансанд бүртгэж, элэгдэл тооцоогүй, өмнөх оны авлагыг барагдуулаагүй зэрэг 16,226.9 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 1.5 дахин их байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан /Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам/-д заасан заалтуудтай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад үйл ажиллагааны орлого өмнөх оноос 257.2 сая төгрөгөөр буурсны дийлэнх хувийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлого (үндсэн хөрөнгө)-ын бууралт, үйл ажиллагааны зардал 221.1 сая төгрөгөөр өссөний дийлэнх хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал эзэлж байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан

4826050192

бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

**Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилт, 30 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг хангаж ажилласнаар Өлзийт сумын засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **4** | **63,578,804.28** | **106,567,294.62** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | | 63,578,804.28 | 106,567,294.62 |
| 31210 | Төгрөг | | 63,578,804.28 | 106,567,294.62 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | 55,790,839.28 | 106,567,294.62 |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | | 7,787,965.00 | |
| **33** | **АВЛАГА** | **5** | **186,576,973.29** | **123,576,583.37** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | 182,256,973.29 | 114,967,818.37 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | | | 4,288,765.00 |
| 33500 | Бусад авлага | | 4,320,000.00 | 4,320,000.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | | 4,320,000.00 | 4,320,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6** | **94,198,861.75** | **49,101,648.72** |
| 35100 | Түүхий эд материал | | 53,405,154.71 | 19,199,491.02 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | 1,358,500.00 | 908,140.00 |
| 35130 | Эм боох материал | | 52,046,654.71 | 18,291,351.02 |
| 35400 | Хангамжийн материал | | 40,793,707.04 | 29,902,157.70 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 259,800.00 | |
| 35420 | Аж ахуйн материал | | 39,119,293.04 | 24,250,390.70 |
| 35450 | Барилгын засварын материал | | 881,000.00 | 1,010,000.00 |
| 35460 | Хүнсний материал | | 283,614.00 | 4,391,767.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 250,000.00 | 250,000.00 |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | | **344,354,639.32** | **279,245,526.71** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7** | **952,951,221.96** | **902,369,423.14** |
| 39200 | Биет хөрөнгө | | 943,002,701.96 | 892,127,569.78 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 664,702,749.44 | 664,702,749.44 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | | - 68,979,213.03 | - 81,116,329.35 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 219,798,434.00 | 219,798,434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | | - 77,921,795.20 | - 101,191,211.92 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | | 244,517,746.05 | 276,662,346.05 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | | - 66,101,147.06 | - 109,819,293.20 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 38,042,200.00 | 42,032,200.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | | - 11,056,272.24 | - 18,941,325.24 |
| 39300 | Биет бус хөрөнгө | | 9,948,520.00 | 10,241,853.36 |
| 39301 | Програм хангамж | | | 440,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж | | | - 146,666.64 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 9,948,520.00 | 9,948,520.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | | **952,951,221.96** | **902,369,423.14** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | | **1,297,305,861.28** | **1,181,614,949.85** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **9** | **2,247,700.00** | **2,783,146.07** |
| 41300 | Өглөг | | 2,247,700.00 | 2,783,146.07 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | | 1,740,009.07 |
| 41311 | Цалингийн өглөг | | | 1,740,009.07 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 2,247,700.00 | 1,043,137.00 |
| 413205 | Тээвэр, шатахууны өглөг | | 2,247,700.00 | 1,043,137.00 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | | **2,247,700.00** | **2,783,146.07** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | **1,295,058,161.28** | **1,178,831,803.78** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 234,664,815.67 | 234,664,815.67 |
| 511002 | Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан | | 234,664,815.67 | 234,664,815.67 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 835,347,796.38 | 719,121,438.88 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 473,413,356.81 | 835,347,796.38 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 361,934,439.57 | -116,226,357.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 225,045,549.23 | 225,045,549.23 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | | **1,295,058,161.28** | **1,178,831,803.78** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)** | | **1,297,305,861.28** | **1,181,614,949.85** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | | |
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **862,302,507.08** | **894,155,070.80** |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | | 51,593,400.00 | 52,986,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 51,593,400.00 | 52,986,100.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | 810,709,107.08 | 841,168,970.80 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | | 810,709,107.08 | 841,168,970.80 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | | **341,072,082.93** | **52,075,466.82** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | | 341,072,082.93 | 52,075,466.82 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 69,400,860.00 | 39,611,079.92 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | | 69,400,860.00 | 39,611,079.92 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 251,353,842.00 | 3,939,100.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | | 20,317,380.93 | 8,525,286.90 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2** | **1,203,374,590.01** | **946,230,537.62** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **841,440,150.44** | **1,062,456,895.12** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 776,374,113.22 | 1,015,386,574.95 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 481,146,520.87 | 600,178,219.79 |
| 210101 | Үндсэн цалин | | 297,948,568.14 | 363,877,419.64 |
| 210102 | Нэмэгдэл | | 138,721,163.23 | 189,798,990.07 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | | 3,420,000.00 | 17,151,010.08 |
| 210104 | Урамшуулал | | 41,056,789.50 | 29,350,800.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 60,017,459.73 | 75,004,373.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 41,405,321.28 | 50,419,133.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 4,670,282.62 | 5,786,122.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 2,889,121.52 | 4,446,193.41 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 2,124,429.07 | 2,782,131.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 8,928,305.24 | 11,570,791.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 43,353,162.78 | 40,883,159.75 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 3,605,528.78 | 5,023,061.75 |
| 210302 | Түлш, халаалт | | 36,147,634.00 | 34,010,298.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 3,600,000.00 | 1,849,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 44,802,899.20 | 94,087,140.18 |
| 210401 | Бичиг хэрэг | | 2,021,350.00 | 7,628,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 25,299,900.00 | 22,906,131.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 955,900.00 | 1,300,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | | 824,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 16,525,749.20 | 30,340,425.34 |
| 210408 | Бараа материал актласны зардал | | | 31,087,483.84 |
| 2105 | Нормативт зардал | | 57,410,531.53 | 61,811,536.75 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 51,473,136.53 | 55,280,787.75 |
| 210502 | Хоол, хүнс | | 5,937,395.00 | 6,530,749.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 14,472,400.00 | 12,595,300.00 |
| 210604 | Урсгал засвар | | 14,472,400.00 | 12,595,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 10,384,000.00 | 8,160,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 10,384,000.00 | 8,160,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 3,356,106.00 | 21,134,025.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 2,258,400.00 | 14,969,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 720,000.00 | 2,016,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 119,250.00 | 3,346,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 167,568.00 | 278,056.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | | 79,944.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 90,888.00 | 4,525.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 61,431,033.11 | 101,532,819.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 5,089,450.00 | 14,376,421.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | | 56,341,583.11 | 87,156,398.82 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 65,066,037.22 | 47,070,320.17 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 58,992,000.00 | 43,544,479.92 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | | | 36,383,479.92 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | | 58,992,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | | 7,161,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 6,074,037.22 | 3,525,840.25 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 6,074,037.22 | 3,525,840.25 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **3** | **841,440,150.44** | **1,062,456,895.12** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | | **361,934,439.57** | **-116,226,357.50** |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | | **361,934,439.57** | **-116,226,357.50** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | |
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **683,315,837.79** | **961,444,225.72** |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 51,593,400.00 | 52,986,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 51,593,400.00 | 52,986,100.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 631,722,437.79 | 908,458,125.72 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 631,722,437.79 | 908,458,125.72 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **65,080,860.00** | **39,611,079.92** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 65,080,860.00 | 39,611,079.92 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 65,080,860.00 | 39,611,079.92 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 65,080,860.00 | 39,611,079.92 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **748,396,697.79** | **1,001,055,305.64** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **757,593,520.52** | **925,431,315.30** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 692,527,483.30 | 874,072,230.13 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 478,879,803.79 | 598,438,210.72 |
| 210101 | Үндсэн цалин | 295,681,851.06 | 362,137,410.57 |
| 210102 | Нэмэгдэл | 138,721,163.23 | 189,798,990.07 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 3,420,000.00 | 17,151,010.08 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 41,056,789.50 | 29,350,800.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,017,459.73 | 75,004,373.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,405,321.28 | 50,419,133.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,670,282.62 | 5,786,122.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,889,121.52 | 4,446,193.41 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,124,429.07 | 2,782,131.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,928,305.24 | 11,570,791.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 43,353,162.78 | 40,883,159.75 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,605,528.78 | 5,023,061.75 |
| 210302 | Түлш, халаалт | 36,147,634.00 | 34,010,298.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,600,000.00 | 1,849,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 29,250,200.00 | 47,312,694.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,690,200.00 | 7,012,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,859,000.00 | 24,110,694.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 955,900.00 | 1,300,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,168,300.00 | 2,787,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,576,800.00 | 12,101,400.00 |
| 2105 | Нормативт зардал | 46,624,401.00 | 58,770,796.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 40,617,541.00 | 45,220,644.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,010,860.00 | 10,895,152.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,996,000.00 | 2,655,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,796,900.00 | 17,564,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 350,000.00 | 930,000.00 |
| 210602 | Тавилга | | 380,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,446,900.00 | 16,254,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,384,000.00 | 8,160,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,384,000.00 | 8,160,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,796,106.00 | 21,372,525.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,698,400.00 | 14,969,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 2,016,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 119,250.00 | 3,346,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 167,568.00 | 278,056.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | 79,944.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 90,888.00 | 4,525.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 238,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,425,450.00 | 6,566,171.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,425,450.00 | 6,566,171.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 65,066,037.22 | 51,359,085.17 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 58,992,000.00 | 43,544,479.92 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | | 36,383,479.92 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 58,992,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 7,161,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 4,288,765.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 4,288,765.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 6,074,037.22 | 3,525,840.25 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,074,037.22 | 3,525,840.25 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)** | **757,593,520.52** | **925,431,315.30** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | **-9,196,822.73** | **75,623,990.34** |
| **14** | **ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО** | | |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,455,000.00** | **32,635,500.00** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 10,455,000.00 | 32,635,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2251 | Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн | 10,455,000.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,455,000.00 | 32,635,500.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **10,455,000.00** | **32,635,500.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)** | **-10,455,000.00** | **-32,635,500.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)** | **-19,651,822.73** | **42,988,490.34** |
| **14** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **83,230,627.01** | **63,578,804.28** |
| **15** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **63,578,804.28** | **106,567,294.62** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **234,664,815.67** | **225,045,549.23** | **473,413,356.81** | **933,123,721.71** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 234,664,815.67 | 225,045,549.23 | 473,413,356.81 | 933,123,721.71 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | | | 361,934,439.57 | 361,934,439.57 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | |
| **11** | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **234,664,815.67** | **225,045,549.23** | **835,347,796.38** | **1,295,058,161.28** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 234,664,815.67 | 225,045,549.23 | 835,347,796.38 | 1,295,058,161.28 |
| **19** | **Тайлант үеийн үр дүн** | | | **-116,226,357.50** | **-116,226,357.50** |
| **20** | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **234,664,815.67** | **225,045,549.23** | **719,121,438.88** | **1,178,831,803.78** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,187,307,600.00 | 946,753,010.05 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,187,307,600.00 | 946,753,010.05 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,142,907,600.00 | 903,208,530.13 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 693,840,300.00 | 598,438,210.72 |
| 210101 | Үндсэн цалин | 391,224,600.00 | 362,137,410.57 |
| 210102 | Нэмэгдэл | 193,082,900.00 | 189,798,990.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 38,295,600.00 | 17,151,010.08 |
| 210104 | Урамшуулал | 71,237,200.00 | 29,350,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 86,645,300.00 | 75,004,373.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,688,500.00 | 50,419,133.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,489,200.00 | 5,786,122.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,244,600.00 | 4,446,193.41 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,244,600.00 | 2,782,131.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,978,400.00 | 11,570,791.72 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,986,100.00 | 40,883,159.75 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,500,000.00 | 5,023,061.75 |
| 210302 | Түлш, халаалт | 33,526,100.00 | 34,010,298.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,960,000.00 | 1,849,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 72,200,400.00 | 47,312,694.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,000,000.00 | 7,012,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,839,700.00 | 24,110,694.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,286,700.00 | 1,300,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,074,000.00 | 2,787,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,000,000.00 | 12,101,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 92,276,900.00 | 58,770,796.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 64,646,900.00 | 45,220,644.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,755,000.00 | 10,895,152.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,875,000.00 | 2,655,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 76,900,000.00 | 50,199,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 35,000,000.00 | 29,575,500.00 |
| 210602 | Тавилга | 3,000,000.00 | 4,370,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 38,900,000.00 | 16,254,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 14,248,000.00 | 8,160,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,248,000.00 | 8,160,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 38,465,100.00 | 21,372,525.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,076,500.00 | 14,969,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,424,700.00 | 2,016,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,716,700.00 | 3,346,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 592,600.00 | 278,056.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 412,000.00 | 79,944.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,320,600.00 | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 220,000.00 | 4,525.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 702,000.00 | 238,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 25,345,500.00 | 3,066,971.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,345,500.00 | 3,066,971.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 44,400,000.00 | 43,544,479.92 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 44,400,000.00 | 43,544,479.92 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 36,400,000.00 | 36,383,479.92 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,000,000.00 | 7,161,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,187,307,600.00 | 997,529,465.39 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 52,986,100.00 | 49,460,259.75 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 52,986,100.00 | 49,460,259.75 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,042,053,000.00 | 908,458,125.72 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,042,053,000.00 | 908,458,125.72 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 92,268,500.00 | 39,611,079.92 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 36,477,600.00 | 39,611,079.92 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 55,790,900.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 55,790,839.28 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 106,567,294.62 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,121.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,740.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулан, 7,474.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 11,906.9 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

***Залруулсан алдаа:***

1. Ажилтны цалинг бодохдоо үндсэн цалинг зөрүүтэй бодож 1,740.0 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т /*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*/заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад бүрэн залруулсан.*

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 19,381.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч 7,474.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 11,906.9 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүллээ.

**3.1 Албан шаардлага**

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин 3,154.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалын нөөц бүрдүүлсэн.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д /*нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх*/ заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.** Өмнөх онд үүссэн 6 ажилчидтай холбоотой 4,320.0 мянган төгрөгийн түрээсийн байрны авлагыг барагдуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 /*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*/, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д /Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/ заасныг мөн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:*

*Дээрх зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ. /Албан шаардлагын хэрэгжилтийг заасан хугацаанд ирүүлэх/*

**3.2 Зөвлөмж**

5.3.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой

*Илрүүлэлт:*

Тайлант хугацаанд 7 нэр төрлийн 11,906.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тусгай зориулалтын бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д /*Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*/, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан /Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам/-д заасныг мөн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:*

Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг эдийн засгийн ангиллын дагуу үнэн зөв бүртгэж, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх;

Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 30 хоногийн дотор, хэрэгжилтийг 2026 оны 06 дугаар сарын 01-ний дотор Төрийн аудитын газарт ирүүлэх.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар 7 нэр төрлийн үндсэн хөрөнгийг тусгай зориулалтын бараа материалын дансанд бүртгэж, элэгдэл тооцоогүй, өмнөх оны авлагыг барагдуулаагүй зэрэг 16,226.9 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 1.5 дахин их тул “ХЯЗГААРЛАЛТТАЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажилтны цалинг бодохдоо үндсэн цалинг зөрүүтэй бодож дутуу цалин олгосон | 1 | 1,740.0 | 1 | 1,740.0 | | | 1 | 1,740.0 | | |
| | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **1,740.0** | **1** | **1,740.0** | | | **1** | **1,740.0** | | |

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өмнөх онд үүссэн 6 ажилчидтай холбоотой түрээсийн байрны авлагыг барагдуулаагүй | 1 | 4,320.0 | | | 1 | 4,320.0 | | | | |
| Тайлант хугацаанд 7 нэр төрлийн үндсэн хөрөнгийг тусгай зориулалтын бараа материалын дансанд бүртгэсэн байна. | 1 | 11,906.9 | | | | | 1 | 11,906.9 | | |
| **Дүн** | **2** | **16,226.9** | | | **1** | **4,320.0** | **1** | **11,906.9** | | |

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тусгай зориулалтын бараа материалын нөөц бүрдүүлсэн байна. | 1 | 3,154.1 | | | 1 | 3,154.1 | | | | |
| **Дүн** | **1** | **3,154.1** | | | **1** | **3,154.1** | | | | |